

ГЭР ХОРООЛЛЫН ИРГЭДИЙН ҮЕРИЙГ ТЭСВЭРЛЭХ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ



GCRP

2025 оны 12 дугаар сарын байдлаар



Чадавхжуулах үйл ажиллагаанд
хамрагдсан хүмүүсийн тоо:

1424 үүнээс эмэгтэй **1027**



Үерийн
хамгаалалтын
сүвгийн урт **3.4 км**

Үерийн ус барих
хоёр усан сангийн
нийт талбай

20,550 м²

Усан сангийн үерийн
ус, халиа дошинг
барих хүчин чадал

54,363 м³



Оршин суугчдын
тарьсан мод, бут
сөөг **900**



Үерт тэсвэртэй
00-н байгууламж **137**

Төслийн зорилго: Голын болон уруйн үер, халиа тошинд автах өндөр эрсдэл бүхий Улаанбаатар хотын гэр хорооллын 8 хорооны иргэдийн үерийг тэсвэрлэх чадавхийг бэхжүүлэх.

Төслийн зорилтууд:

- ✓ Улс, орон нутгийн түвшний бодлого, зохицуулалтыг сайжруулах замаар хот суурин газрын уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн эрсдэлийг бууруулах, дасан зохицох чадавхийг нэмэгдүүлэх;
- ✓ Уур амьсгалын өөрчлөлтөд одоо болон ирээдүйд дасан зохицох чадавхийг улс, орон нутаг, олон нийтийн түвшинд бий болгох;
- ✓ Зорилтот гэр хорооллын нутаг дэвсгэрт үерээс хамгаалах байгууламж барих замаар үерийн эрсдэлийг бууруулах;
- ✓ Төслийн үр дүнгийн тогтвортой байдлыг хангах, өөр газар нутагт хэрэгжүүлэх мэдлэг, мэдээллийн санг сайжруулах.

Санхүүжүүлэгч байгууллага: Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох сан (ADAPTATION FUND)

Хэрэгжүүлэгч байгууллага: НҮБ-ын Хүн амын нутагшил суурьшлын хөтөлбөр буюу НҮБ-ын Хабитат, Хөгжлийн шийдэл ТББ

Хамтран хэрэгжүүлэгч: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Нийслэлийн Захирагчийн ажлын алба, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газар

Хэрэгжих хугацаа:
Хэрэгжих талбар:

Санхүүжилт:

4 жил
Сонгинохайрхан дүүргийн 4, 5, 26, 27, Сүхбаатар дүүргийн 15, 16, 18, 20
7.9 сая ам.доллар



976-11322711



www.facebook.com/ubfruga



un-habitat.mn



Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, 40 50 мянгат, Жуулчны гудамж, 34-р байр 7-1 тоот



ЗОРИЛТ 2

Уур амьсгалын өөрчлөлтөд одоо болон ирээдүйд дасан зохицох чадавхийг улс, орон нутаг, олон нийтийн түвшинд бий болгох



Ц.Цогтгэрэл, М агро компанийн ХАА-н мэргэжилтэн

Гэр хорооллын иргэдийн үерийн тэсвэрлэх чадавхийг бэхжүүлэх төслийн Уур амьсгалын өөрчлөлтөд одоо болон ирээдүйд дасан зохицох чадавхийг улс, орон нутаг, олон нийтийн түвшинд бий болгох зорилтын хүрээнд “Эргийн хамгаалалтын бүсэд мод тарих, үрсэлгээ бэлтгэх сургалт”-г төсөл хэрэгжиж буй хороодод байгуулагдсан бүлгүүд, оршин суугчдын зөвлөлийн гишүүдэд хамруулан нийт 43 хүнтэйгээр 4 сарын 18-ны өдөр амжилттай зохион байгуулсан. Сургалтад М агро ХХК-н хөдөө аж ахуйн мэргэжилтэн Ц.Цогтгэрэл оролцож, иргэдэд голын эрэг, булаг шандтай газруудад ургах боломжтой мод ургамлыг тариалах арга туршлагын талаар ойлголт өгөхийн зэрэгцээ үерийн далангийн хэсгийг ногоон ургамлаар бүрхэх, орчныг илүү ногоон болгох талаар мэдээлэл, сайн туршлагуудыг хуваалцсан.

Энэхүү үйл ажиллагааны хүрээнд 5 сарын 15, 16-ны өдрүүдэд Төслийн багийн гишүүд болон иргэдийн төлөөллөөс бүрдсэн 15 гишүүнтэй баг Хэнтий айгийн Хэрлэн сумын 7-р багийн нутагт дэвсгэрт байрлах М Агро ХХК-н байранд зочилж, компанийн зүгээс үерийн эрсдэлс хамгаалах хөв цөөрөм, эргийн бэхэлгээнд мод зүлэг тарьсан сайн туршлагатай газар дээр нь танилцаж, туршлага судалсан. Туршлага судлах аялалын хүрээнд М Агро ХХК-н ажилтан Ш.Алтанбадралт нь компанийн үйл ажиллагааны дэлгэрэнгүй танилцуулахын зэрэгцээ таримал ургамал тариалах үрийг хэрхэн бэлтгэх талаар зөвлөгөө, мэдээлэл хуваалцсан. Мөн М Агро ХХК-н Агрономич Ц.Цогтгэрэл нь голын эрэг, булаг шандыг хамгаалж, моджуулахын ач холбогдол, анхаарах зүйлсийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл хуваалцсан.



ЗОРИЛТ 3

Гэр хорооллын орчинд тохирсон ариун цэврийн байгууламжийг хөгжүүлэх, одоогийн нөхцөл байдлыг сайжруулах боломжийг хэлэлцлээ



НҮБ-ын Суурьшлын Хөтөлбөрийн “Гэр хорооллын иргэдийн үерийг тэсвэрлэх чадавхийг бэхжүүлэх” төслийн хүрээнд “Гэр хорооллын орчинд тохирсон ариун цэврийн байгууламжийг сайжруулах, хөгжүүлэх боломжууд” сэдэвт семинарыг Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргийн оршин суугчдын бүлгийн иргэд, ариун цэврийн байгууламжийн угсралт, суурилуулалт хийдэг компани болон мэргэжлийн байгууллагын төлөөллийг хамруулан 2025 оны 7-р сарын 31-ний өдөр зохион байгууллаа.

Семинарын үеэр Сүхбаатар болон Сонгинохайрхан дүүрэгт байгуулсан оршин суугчдын бүлгийн төлөөллүүд 2021 оноос хойш өөрсдийн хийж, айл өрхүүдэд суурилуулж буй өрхийн ариун цэврийн байгууламжийн сайн туршлага, хөгжүүлэлт, цаашдын төлөвлөгөөг хуваалцаж, бусад оролцогчидтой санал солилцсон. Мөн Их хаан бугуйвч ХХК, Монголын жорлонгийн

холбоо зэрэг мэргэжлийн байгууллагууд айл өрх болон нийтийн ариун цэврийн байгууламжийн сүүлийн үеийн технологи, чиг хандлага, олон улсын сайн туршлагыг хуваалцаж, оролцогчдын сонирхсон асуултуудад дэлгэрэнгүй хариултууд өгч, цаашдаа хамтран ажиллахаа илэрхийллээ.

Семинарын үр дүнд “Гэр хорооллын иргэдийн үерийг тэсвэрлэх чадавхийг бэхжүүлэх” төслийн зүгээс айл өрхийн ариун цэврийн байгууламжийг сайжруулах, шинэ технологи нэвтрүүлэх ажлын хэсгийг байгуулж, дэмжин ажиллахаа илэрхийлсэн бөгөөд ажлын хэсэгт Монголын жорлонгийн холбоо, Их хаан бугуйвч ХХК, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргийн оршин суугчдын бүлгүүд, иргэд болон төслийн багийн гишүүдийг оролцуулахаар болсон.



МЭДЭЭ

“Шинэ хотын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, тогтвортой хот байгуулалтыг дэмжих нь” өглөөний уулзалт амжилттай зохион байгуулагдлаа.



Дасан зохицох сангийн санхүүжилтээр UN-HABITAT in Mongolia НҮБ-ын Хүн Амын Нутагшил Суурьшлын Хөтөлбөр болон Development Solutions NGO - Хөгжлийн Шийдэл ТББ хэрэгжүүлж буй “Гэр хорооллын иргэдийн үерийг тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх” төслийн хүрээнд “Шинэ хотын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, тогтвортой хот байгуулалтыг дэмжих нь” сэдэвт өглөөний уулзалт 2025 оны 12 сарын 11-ний өдөр амжилттай болж өнгөрлөө. Энэхүү уулзалтад НҮБ-ын Монгол дахь Суурин зохицуулагч Яап Ваан Хирден, НҮБ-ын Суурьшлын хөтөлбөрийн Ази, Номхон далайн бүсийн Суурьшлын зохицуулагч Рой Чити нар хүрэлцэн ирж нээлтийн үг хэлэв. Мөн Хот байгуулалт, барилга, орон сууцны яам, Улаанбаатар хотын захиргаа, Дархан, Эрдэнэт, Чингис, Сүхбаатар, Булган, Цэцэрлэг, Зуунмод, Хүннү, Хар Хорум зэрэг хотуудын удирдлага, холбогдох албан тушаалтнууд болон бусад салбарын төлөөллүүдээс бүрдсэн 45 орчим оролцогч уулзалтад оролцлоо.

Өглөөний уулзалтын үеэр хотын тогтвортой хөгжил, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлого, төлөвлөлтийг хот суурингийн түвшинд уялдуулахад чиглэсэн чухал сэдвүүдийн хүрээнд мэдээлэл, туршлага солилцлоо. НҮБ-ын Суурьшлын хөтөлбөрийн Ази, Номхон далайн бүсийн Суурьшлын зохицуулагч Рой Чити НҮБ-ын Суурьшлын хөтөлбөрийн дэлхийн хэмжээнд, бүс нутгийн болон Монгол Улсад хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, мөн Дэлхийн хот байгуулалтын 13-р чуулганы зорилго, санаачилгуудын талаар дэлгэрэнгүй танилцуулга хийв. Мөн төслийн хамтран ажиллагч судалгааны багийн ахлагч Доктор М.Алтанбагана НҮБ Хабитат III хурлаар баталсан Шинэ хотын хөтөлбөр (New Urban Agenda)-ийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын тайлангийн бэлтгэлийн явцыг танилцууллаа. Тэрбээр энэхүү тайлан нь 47 зүйл бүхий үнэлгээнд суурилж хийгддэг бөгөөд Монгол Улс уг тайланг 2025 ондоо багтаан НҮБ-д хүргүүлэх шаардлагатайг онцолсон юм.

Түүнчлэн Монгол Улсын Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагааны төлөвлөгөө 3 (NAP), Үндэсний тодорхойлсон хувь нэмэр 3 (NDC 3.0) зэрэг бодлогын баримт бичгүүдийн агуулга, эдгээрийг хот суурингийн бодлого, төлөвлөлтөд хэрхэн тусгах, дасан зохицох арга хэмжээг хотын хөгжлийн баримт бичгүүдэд яаж уялдуулах талаар “Уур Амьсгалын өөрчлөлт - хөгжил” академийн тэргүүн Доктор Д.Дагвадорж танилцуулга хийж, хэлэлцүүлэг өрнүүллээ. Хэлэлцүүлгийн үеэр судлаачид болон мэргэжилтнүүд дээрх бодлогын баримт бичгүүдийн тайлан, үнэлгээг чанартай боловсруулахад нийслэлээс гадна орон нутгийн хот, тосгодын бодит дата мэдээлэл нэн чухал болохыг онцолсон юм. Харин уулзалтад оролцсон хотуудын төлөөллүүд одоогоор хот төлөвлөлтийн болон хөгжлийн баримт бичгүүдээ шинээр боловсруулах, шинэчлэх ажлыг эхлүүлээд байгаа бөгөөд энэхүү уулзалтаас олж авсан мэдлэг, мэдээлэл нь тэдний ажилд бодит дэмжлэг болж байгааг илэрхийллээ. Мөн цаашид НҮБ-ын Суурьшлын хөтөлбөрөөс арга зүйн дэмжлэг авах сонирхлоо илэрхийлж байсан юм.

Арга хэмжээний дараа НҮБ-ын Суурьшлын хөтөлбөрийн зүгээс оролцогчдын хамтын ажиллагааг үргэлжлүүлэн дэмжих зорилгоор мэдээлэл солилцох, туршлага хуваалцах хамтарсан групп байгуулах, мөн 2026 онд Азербайжаны Баку хотод зохион байгуулагдах Дэлхийн хотын форум (World Urban Forum)-д Монгол Улсаас хотуудын өргөн бүрэлдэхүүнтэйгээр хамтран оролцох санаачилгыг дэвшүүллээ. Энэхүү өглөөний уулзалт нь хотуудын тогтвортой хөгжил, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлого, төлөвлөлтийг уялдуулах, олон талын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх чухал эхлэл боллоо.



МЭДЭЭ

Иргэдийн оролцоонд суурилсан хөгжлийн сайн туршлагыг хуваалцах арга хэмжээ боллоо



Дасан зохицох сангийн санхүүжилтээр НҮБ-ын Хүн амын нутагшил, суурьшлын хөтөлбөр болон Хөгжлийн Шийдэл ТББ хамтран хэрэгжүүлж буй “Гэр хорооллын иргэдийн үерийг тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх” төслийн хүрээнд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Иргэдийн оролцоотой хэрэгжиж буй хөгжлийн үйл ажиллагааны туршлага солилцох” уулзалт амжилттай боллоо. Энэхүү арга хэмжээ нь тухайн жилд төслийн хүрээнд идэвхтэй ажилласан оршин суугч иргэдийн бүлгүүд өөрсдийн үерийн эрсдэлийг даван туулах, амьдрах орчноо хамтын оролцоонд тулгуурлан сайжруулсан бодит туршлага, санаачилгаа харилцан хуваалцаж, бие биеэсээ суралцах зорилготойгоор зохион байгуулагддаг.

Энэ жилийн уулзалтад Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн иргэдийн бүлгүүдийн ахлагчид иргэд нэгдэн нийлж бүлэг болж, хамтын оролцоонд тулгуурлан амьдрах орчноо хэрхэн сайжруулж ирсэн бодит туршлагаасаа хуваалцлаа. Тухайлбал, үерийн эрсдэлд тэсвэртэй нойлын шийдэл, явган хүний зам, гүүр, шат, мод тарих, ногоон байгууламж зэрэг орчны тохижилтын ажлуудыг иргэдийн өөрсдийн санаачлага, оролцоотойгоор хэрэгжүүлсэн туршлагууд онцлог байв. Харин төслийн багийн зүгээс иргэдийн оролцооны аргачлал, гэр хорооллын бүс нутагт тойрог эдийн засгийг хөгжүүлэх боломж зэрэг сэдвүүдийн

хүрээнд сургалт, танилцуулга хэлбэрээр илтгэлүүдийг хүргэлээ. Арга хэмжээнд нийт 130 орчим оролцогч оролцсон бөгөөд иргэдийн төлөөллөөс гадна төслийн хүрээнд зохион байгуулагдсан “Шинэ хотын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, тогтвортой хот байгуулалтыг дэмжих нь” сэдэвт өглөөний уулзалтад оролцохоор хүрэлцэн ирсэн Дархан, Эрдэнэт, Чингис, Сүхбаатар, Булган, Цэцэрлэг, Зуунмод, Хүннү, Хар Хорум зэрэг хотуудын удирдлага, холбогдох албан тушаалтнууд оролцлоо. Тэд төслийн хүрээнд эвлэлдэн нэгдсэн иргэдийн бүлгүүдийн санаачилга, сайн туршлагуудтай танилцаж, өөрсдийн орон нутагт иргэдийн оролцоонд суурилсан хөгжлийн практик боломжуудын талаар мэдлэг, ойлголт авснаараа онцлог ач холбогдолтой байв.

Мөн арга хэмжээний үеэр төслийн багийн зүгээс иргэдийн бүлгүүдийн амьдрах орчин, ахуй нөхцлөө сайжруулж буй бодит түүх, туршлагуудыг нэгтгэсэн товхимлыг хэвлэн гаргаж, оролцогчдод тараасан нь мэдлэг, туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд чухал хувь нэмэр орууллаа. Энэхүү арга хэмжээ нь хотын тогтвортой хөгжил, үерийн эрсдэлийг даван туулах дасан зохицох үйл ажиллагаанд иргэдийн оролцоо, манлайлал, орон нутгийн санаачилга чухал болохыг харуулсан төдийгүй эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй болон асаргаа шаардлагатай иргэдийн тэгш оролцоонд онцгой анхаарч ажиллаж буйг тодотгосон чухал уулзалт боллоо.



МЭДЭЭ

“Уур амьсгалын өөрчлөлт бидний амьдралд” Гар зургийн уралдаан амжилттай зохион байгуулагдлаа.



UN-HABITAT in Mongolia НҮБ-ын Хүн Амын Нутагшил Суурьшлын Хөтөлбөр нь Улаанбаатар хотын гэр хорооллын иргэдийн үерийг тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлж, илүү аюулгүй, эрүүл, ногоон орчин бий болгохын төлөө ажиллаж байна. Бидний амьдрах орчныг хамгаалж, илүү сайхан хот, илүү ногоон орчныг бүтээхэд хүн бүрийн оролцоо чухал. Тэрдундааирээдүйнхотынээздболохурамзоригтой, бүтээлч хүүхдүүдийн оролцоо хамгийн үнэ цэнтэй.




Энэ хүрээнд гэр хорооллын бүс болох Сүхбаатар дүүргийн 18-р хороонд байрлах 71-р сургуулийн сурагчдын дунд гар зургийн уралдааныг зохион

байгууллаа. Бид хүүхдүүдийнхээ зүрхэнд ногоон сэтгэлгээ, хотынхоо ирээдүйг хайрлах урам зоригийг суулгаж чадвал илүү аюулгүй, тогтвортой, ээлтэй Улаанбаатарыг хамтдаа бүтээж чадна.

Энэхүү уралдааныг зохион байгуулахад идэвхтэй дэмжлэг үзүүлсэн

* Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар болон тус Дүүргийн Менежер,

* 71-рсургуулийнудирдлага,багшнарболоноролцсон бүхсурагчиддаа чин сэтгэлийн талархал илэрхийлье.



АМЖИЛТЫН ТҮҮХ Н.Туяагийн гэрэлтэй замнал



"Төслийн үр дүнд хашаа хороо, гудамж талбай маань хуурай, би өөрөө бусдад үлгэрлэсэн, өөртөө итгэлтэй ахлагч болсон байна."

Сонгинохайрхан дүүргийн 40-р хорооны оршин суугч Н.Туяа болон түүний гэр бүл олон жилийн турш нэгэн ижил хүнд сорилттой тулж иржээ. Тэдний амьдарч буй гудамж нь зундаа үерийн усанд автаж, өвөлдөө газар хөлдөхтэй холбоотой байшин нь цуурч, тавилга эвдэрч, амьдрахад хүндрэлтэй болдог байв. Түүгээр ч зогсохгүй өвөлдөө маш их даарч, зундаа байнга л усны гутал өмсөх шаардлагатай байдаг байсан. Эдгээр асуудлууд нь жил бүр тохиолдох нь тэдний гэр бүлд санхүүгийн хувьд ч асар их дарамтыг үүсгэж байлаа. Мөн эрүүл мэндийн шалтгаанаас болж гэр бүлийн гишүүнээ асарч, гэрээсээ ч гарах завгүй байсан тул маш их ганцаардал, бухимдал дунд амьдарч иржээ.

"Өвөлдөө ханаараа цуурч, доторх тавилга эвдэрч гэмтсэн байшин, зундаа үерийн ус, шавхайгаар дүүрсэн гудамж, үүнийг туулахын тулд усны гутал байнга өмсөх шаардлагатай нөхцөлтэй нүүртүлдэг байлаа." Н.Туяа, СХД-н 40-р хорооны оршин суугч

Харин түүний эдгээр хүндрэлтэй асуудал, бэрхшээлийг даван гарах, ялалт байгуулах эхний алхам нь "Гэр хорооллын иргэдийн үерийг тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх төсөл"-тэй холбогдсон явдал байсан юм. Учир юу вэ гэхээр тэрээр төслийн хамт олонтой маш сайн харилцаа холбоо тогтоож, өөрийн оршин сууж буй хороо, гудамжны иргэдийг үр дүнтэй зохион байгуулж, гудамжиндаа хөрс, үерийн ус зайлуулах шугам, дэд бүтцийг бий болгосноор түүнд болон түүний эргэн тойронд байдаг олон айл өрхүүдэд олон жил ужигран тохиолдсон зовлонг арилгаж чадсан юм. Хөрс, үерийн усны асуудал байхгүй болсноор тэдний амьдарч буй байшинд дахин цууралт гарахаа больж, тавилга, эд хогшилд эвдрэл гарахаа больсон. Мөн төслийн багаас соруулдаг битүүмж сайтай ариун цэврийн байгууламж суурьлуулж өгснөөр гэр бүлийн гишүүдийн ахуйн нөхцөлийг мэдэгдэхүйц сайжруулсан.

Н.Туяа нь төслийн хүрээнд зохион байгуулдаг сургалт, уулзалтад идэвхтэй хамрагдаж, бусдыг манлайлах, нэгтгэх, хамтран ажиллах ур чадвараа сайжруулж, гамшгийн үед өөрийгөө болон гэр бүлээ хамгаалах мэдлэг, ур чадварыг эзэмшсэн. Ингэснээр тэр хөршүүдийнхээ итгэлийг хүлээсэн "Хамтын хүч" бүлгийн ахлагч болоод байна. Мөн тэрээр өөрийн амьдралд бий болсон хамгийн чухал өөрчлөлт нь зөвхөн үеэр, усны асуудал биш амьдралын минь утга учрыг дахин бий болгосон бөгөөд одоо бусадтай холбогдож, хамтдаа инээж, асуудлаа шийдэж чаддаг болсон нь түүний төслөөс хүртсэн хамгийн том үр шим болохыг илэрхийлсэн.

"Гэр хорооллын иргэдийн үерийг тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх төсөл" нь зөвхөн нэг гэр бүлийг биш хөршүүдийг гудамжаар нь өөрчиллөө. Төслөөс өмнө нь нүүж явсан олон айлууд эргэн ирж, айл өрхүүдийн хашаа байшингийн үнэ өсөж, иргэд хамтдаа мод ногоо тарьж, хог цэвэрлэж, асуудлаа ярилцдаг болсон. Өмнө нь байгалийн давагдашгүй мэт бэршээлд автан ганцаардаж байсан Туяа өнөөдөр хөршүүдээ уриалан манлайлагч болж, өөртөө итгэлтэй, бусдад итгэл найдвар түгээгч нэгэн хүчирхэг эмэгтэй болсон.



ЗӨВЛӨМЖ

ҮЕРИЙН АЮУЛААС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ НЬҮерийн аюул тохиолдоход амь насаа хамгаалах нь чухал

- Байшингийн дээвэр, ургаа мод зэрэг аль ойрхон өндөрлөг газар гарах



- Үер бууж болзошгүй хавцал, хонхор, нам дор газраас хол байж аль ойр байгаа өндөрлөг гарч тэндээ хүлээх



- Гол мөрөн үертэй үед усанд орох, гол гатлах, загасчлах, усны эрэг орчмоос хол байх



- Усархаг, үргэлжилсэн хүйтэн бороотой үед болон аадар бороо, мөндөр орж байхад мал хариулах, эрэлд явах, мал услах, мал туухгүй байх



- Аялал зугаалга, аян замд гарахыг хойшлуулах

ҮЕРИЙН АЮУЛЫН ДАРАА ТА ЮУГ АНХААРАХ ШААРДЛАГАТАЙ ВЭ?



Хүүхдийг хараа хяналтгүйгээр гол мөрөн, нуур, цөөрмийн орчимд тоглуулахгүй, орхихгүй байх

